



БУЛГАН АЙМГИЙН
ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2019 оны 04 сарын 26-ны өдөр

Дугаар А/8

Булган

Үлийн цагаан оготнотой тэмцэх ажлыг
зохион байгуулах тухай

Ургамал хамгааллын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, 10.1.2 дахь заалт, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2019 оны А/86 дугаар тушаал, аймгийн Засаг даргын 2019 оны А/235 дугаар захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

Нэг. Бэлчээрийн талбайд байгальд халгүй аргаар үлийн цагаан оготнотой тэмцэх арга хэмжээг зохион байгуулах сумдын талбайн хэмжээ, шаардагдах төсвийг нэгдүгээр хавсралтаар, хяналт тавих зардлын төсвийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

Хоёр. Арга хэмжээг хэрэгжүүлэх, сумдтай гэрээ байгуулах, ажлыг хэсэг томилуулах, сургалт явуулах, холбогдох мэргэжилтнүүдийг сум хариуцуулж ажиллуулах, ажлын явц гүйцэтгэлд хяналт хийлгэх, техникийн үр дүнг тодорхойлох, дүгнэлт гаргуулах, тайлан мэдээ судалгаа, акт материалыг зааврын дагуу бүрдүүлэх ажлыг хугацаанд нь чанартай зохион байгуулахыг Мал аж ахуйн албаны дарга / М.Жавзандолгор/-д даалгасугай.

ДАРГА

Ч.АМГАЛАН